

АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 4-Р УЛИРАЛД
ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН БИЧМЭЛ ТАЙЛАН

2025.01.09

1. МАЛ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

2024-2025 өвөлжилт хаваржилтын талаар:

2024-2025 онд 8538 малчин өрхөд 1754657 толгой мал / бод 398.0, бог 1356.0/ өвөлжиж хаваржих дүн гараад байна.

Өөрийн аймгийн бусад сумдын нутагт 950 өрхийн 86,1 мянган толгой мал, хилийн зурваст 268 өрхийн 162,0 толгой мал, улсын тусгай хамгаалалттай бүс нутагт 264 өрхийн 72,0 мянган толгой мал, өөр аймгийн нутагт 15 өрхийн 9,0 толгой мал өвөлжих урьдчилсан дүн гараад байна.

Засгийн газрын 28 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 06 тоот албан даалгаврын дагуу аймгийн аюулгүйн нөөцөд 150 тн өвс 60 тн тэжээл бэлтгэхээс 342 тн өвс, 6289,4 тн тэжээл бэлтгэсэн. Сумдын аюулгүйн нөөцөд 780 тн өвс 390 тн тэжээл бэлтгэхээс 826 тн өвс 399 тн тэжээл бэлтгэсэн. Малчдын түвшинд 25509 тн өвс, 117 тн ногоон тэжээл, 427 тн үйлдвэрийн тэжээл, 366 тн гар тэжээл, 476 тн давс хужир шүү бэлтгэсэн.

Засгийн газрын 28-р тогтоол, ХХААХҮСайдын 02, аймгийн Засаг даргын 06 тоот захирамжийн хэрэгжилтийг газрын даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг гарч 13 суманд өвөлжилтийн бэлтгэл хангалтын талаар мониторинг хийсэн.

Аймгийн хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл хангалт 88%-тай байна.





Хоёр: Бэлчээр, худаг уст цэгийн талаар:

Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг сайжруулах нь /АДАПТ/ төсөлтэй хүсэлт тавьж Асгат, Баяндэлгэр, Наран, Онгон, Дарьганга, Халзан, Түвшинширээ, Уулбаян, Эрдэнэцагаан сумдад 16 худаг гаргуулах шийдвэр гаргуулан 15 худгийг гаргаж хяналт хийх ажлын хэсэг гарч газар дээр нь үзэж танилцан, худаг тус бүрийг шавхалт хийж хүлээн аваад байна.





Мөнххаан сумын Наран сарангийн талд 200 га хадлангийн талбай хаших ажил хийгдэж байна.



Ургамал хамгаалалын эрдэм шинжилгээний хүрээлэнгийг гаргасан бэлчээрийн мэрэгч үлийн цагаан огтонын судалгаагаар аймгийн хэмжээнд 344,400 га талбайд үлийн цагаан огтоны нягтралын голомт өндөртэй гэж гарсан.

ХХААХҮсайдын 2024 оны 02-р сарын 15-ны өдрийн А/96 тоот тушаалаар энгийн механик биологийн аргаар 40 мянган га талбайд тэмцэх хөрөнгийн асуудал шийдвэрлэгдсэн ба аймгийн Засаг даргын 2024 оны 10-р сарын 07-ны өдрийн А/574 тоот захирамжаар 8 суманд уг ажлыг зохион байгуулан дүн мэдээг нэгтгээд байна.



Гурав: Эрчимжсэн мал аж ахуйн талаар:

Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн судалгааг сумдаас авч нэгтгэхэд аймгийн хэмжээнд 11 сумын 48 иргэн аж ахуйн нэгж эрчимжсэн аж ахуй эрхэлж байна. Үүнээс сүүний үхрийн чиглэлээр 892 толгой үхрийг 19 иргэн, аж ахуй нэгж, махны үхрийн чиглэлээр 12 иргэн аан 1206 толгой үхэр, 125 толгой гахайг 7 иргэн, 2 ААН, 1 иргэн 20 бүл зөгий, 3 иргэн, 1 аан 2497 тооны тахиа, шувууг эрчимжсэн хэлбэрээр өсгөн үржүүлж байна.

2. ҮЙЛДВЭРЛЭЛ ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Нэг. Хүнсний үйлдвэр, худалдаа, нийтийн хоолны чиглэлээр

Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран "Хоол үйлдвэрлэлийн салбарт эрүүл ахуйн зохистой дадал нэвтрүүлэх нь" сургалт, 11 сарын 1-3 ны өдөр Баяндэлгэр суманд /7 сумын 65 оролцогч/ амжилттай зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд 13 сумын сургууль, цэцэрлэг, эмнэлэг, цэргийн анги, МСҮТ-ийн оюутан тогооч, ресторан, зоогийн газар, талх нарийн боов үйлдвэрлэгч, ЕБС, СӨБ-ийн хоол зүйч, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүд нийт 160 хүн оролцов.



3. ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ ХОРШОО АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭ

“ЗЭЭЛДЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-МОНИТОРИНГ ХИЙСЭН, ЗӨРЧИЛ АРИЛГУУЛСАН

Энэ хугацаанд 19 аж ахуй нэгжийн **92,659,643** төгрөгийн орлогыг 100900037019 /Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан/ тоот дансанд төвлөрүүлж ажилласан. Мөн 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар **1,431,800,833** төгрөгийн үндсэн зээлийн үлдэгдэлтэй 19 зээлтэй тооцоо нийлэх ажлыг зохион байгуулж ажилласан байна.

- Төсөл хэрэгжсэн- 1.1 тэрбум төгрөгийн үндсэн зээлийн үлдэгдэлтэй 16 төсөл;
- Төсөл хэрэгжих шатандаа- 32.8 сая төгрөгийн үндсэн зээлийн үлдэгдэлтэй 1 төсөл;
- Төслийн хэрэгжилт хангалтгүй- 70.0 сая төгрөгийн үндсэн зээлийн үлдэгдэлтэй 1 төсөл
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжсэн төсөл байхгүй.

2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар

ДД	№	Нэрс	Регистер	Аймаг	Сум	Салбар	Олгосо н огноо	Олгосон зээлийн хэмжээ	Төлөв
1	1	Чулуун дарь овоо ХХК	3681564	Сүхбаатар	Баруун-Урт	Үслэг, нэхий, арьсан эдлэл үйлдвэрлэл	2020	45,000,000	Төсөл хэрэгжсэн
2	2	Билэгт сувдан нуур ХХК	3869679	Сүхбаатар	Баруун-Урт	арьсан бүтээгдэхүүн/ гутал/ үйлдвэр	2023	70,000,000	Төслийн хэрэгжилт хангалтгүй
Хэсгийн дүн								115,000,000	
3	3	Мөнгөн саам хоршоо ХХК	2372533	Сүхбаатар	Баруун-Урт	Малын тэжээлийн үйлдвэрлэл	2021	60,000,000	Төсөл хэрэгжсэн
								60,000,000	
4	4	Гал Бадрах Өөдөө ХХК	3681807	Сүхбаатар	Халзан	мах боловсруулах үйлдвэр	2023	100,000,000	Төсөл хэрэгжсэн
5	5	Сүхбаатарын зам нэгдэл хоршоо	3680851	Сүхбаатар	Түмэнцогт	мах боловсруулах үйлдвэр	2019	280,000,000	Төсөл хэрэгжсэн
Хэсгийн дүн								380,000,000	
6	6	Дархан хаан шүтээн ХХК	3684369	Сүхбаатар	Баруун-Урт	сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах	2023	33,700,000	Төсөл хэрэгжсэн
Хэсгийн дүн								33,700,000	
7	7	Наран түмэн эсгий ХХК	3680576	Сүхбаатар	Наран	Эсгий эдлэлийн үйлдвэрлэл	2020	87,000,000	Төсөл хэрэгжсэн
Хэсгийн дүн								87,000,000	
8	8	Хос Хатан Тунамал ХХК	3685705	Сүхбаатар	Баруун-Урт	оёмол бүтээгдэхүүн	2023	98,614,000	Төсөл хэрэгжсэн
9	9	Бумт алтан шаглаа хоршоо	3686159	Сүхбаатар	Баруун-Урт	оёмол бүтээгдэхүүн	2023	50,000,000	Төсөл хэрэгжсэн
Хэсгийн дүн								148,614,000	
10	10	Бат гарьд эрдэс баяр ХХК	3677125	Сүхбаатар	Баруун-Урт	Хүлэмжийн аж ахуй	2020	265,000,000	Төсөл хэрэгжсэн
11	11	Жаргал Дата ХХК	3682595	Сүхбаатар	Баруун-Урт	Хүлэмжийн аж ахуй	2023	32,800,000	Төсөл хэрэгжих шатандаа
Хэсгийн дүн								297,800,000	

12	12	Ашид мөнх баян хоршоо	3676307	Сүхбаатар	Мөнххаан	Мал аж ахуй	2021	114,000,000	Төсөл хэрэгжсэн
13	13	Билэгт Тусч Хүү	3682676	Сүхбаатар	Баруун-Урт	Үхрийн ферм	2022	72,000,000	Төсөл хэрэгжсэн
14	14	Цэцээ ван ХХК	3675173	Сүхбаатар	Баруун-Урт	гахайн аж ахуй	2023	100,000,000	Төсөл хэрэгжсэн
15	15	Цэцдөл ХХК	3685608	Сүхбаатар	Баруун-Урт	эрчимсэн аж ахуй	2023	100,000,000	Төсөл хэрэгжсэн
16	16	Зараагийн буян овоо ххк	3685683	Сүхбаатар	Баруун-Урт	эрчимсэн аж ахуй	2023	100,000,000	Төсөл хэрэгжсэн
17	17	Мөнхмандалдэлгэр	3681343	Сүхбаатар	Баруун-Урт	Өсвөр хээлтүүлэгч бойжуулах аж ахуй	2023	296,100,000	Төсөл хэрэгжсэн
18	18	Эм Си Ти Жи ХХК	3674886	Сүхбаатар	Баруун-Урт	тахиааны аж ахуй	2023	100,000,000	Төсөл хэрэгжсэн
Хэсгийн дүн								882,400,000	
19	19	Буман төл ХХК	2132524	Сүхбаатар	Мөнххаан	мал эмнэлэг	2023	99,200,000	Төсөл хэрэгжсэн
Хэсгийн дүн								99,200,000	
Нийт								2,103,800,000	

2.ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДАЛ, ТӨЛӨВӨӨР

Байршил	Төслийн тоо	Зээлийн үлдэгдэл /тэрбум төг/	Үүнээс	Төсөл хэрэгжсэн		Төсөл хэрэгжилт шатандаа		Төслийн хэрэгжилт хангалтгүй		Хяналтад хамрагдаагүй		Төслийн хаасан	
				Тоо	Зээлийн үлдэгдэл /тэрбум төг/	Тоо	Зээлийн үлдэгдэл /тэрбум төг/	Тоо	Зээлийн үлдэгдэл	Тоо	Зээлийн үлдэгдэл /тэрбум төг/	Тоо	Зээлийн үлдэгдэл /тэрбум төг/
Сүхбаатар	19	2.1		16	1.2	1	32.8	1	70.0			1	0

3.ТӨСЛИЙН ХЯНАЛТАД ХАМРАГДСАН ТӨСЛҮҮД, САЛБАРААР

№	СҮХБААТАР АЙМАГ				
	САЛБАР	Төслийн тоо	Олгосон хэмжээ	Үндсэн зээлийн үлдэгдэл	Зорчлийн дүн
			/тэрбум төг/	/тэрбум төг/	/сая төг/
1	Агро, ойн аж ахуй, мод үржүүлэг				
2	Арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2	115.0	82.7	6,8
3	Аялал жуулчлал				
4	Бусад	1	99.2	91.6	
5	Газар тариалан				
6	Гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл				
7	Гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл				
8	Жимс, хүнсний ногоо боловсруулах үйлдвэрлэл				
9	Зоорь, агуулах				
10	Малын тэжээл, бордооны үйлдвэрлэл	1	60.0	35.8	
11	Мах, дайвар бүтээгдэхүүн боловсруулах	2	380.0	96.0	
12	Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл				
13	Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1	87.0	32.0	
14	Оёмол, сүлжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2	148.6	141.6	
15	Сав баглаа боодол				

16	Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	1	33.7	33.7	
17	Хөдөө аж ахуйн бэлтгэн нийлүүлэлт				
18	Хүлэмжийн аж ахуй	2	297.8	113.3	8.1
19	Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл				
20	Цэвэр усны үйлдвэрлэл				
21	Эрүүл мэнд, ариутгал				
22	Эрчимжсэн мал аж ахуй	7	882.5	804.6	2.8
	НИЙТ	19	2.1	1.4	17.7

4. ТӨСЛӨӨ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЖИШЭЭ

1. ЭМ ТИ СИ ЖИ ХХК:

<u>Зээлийн дүн:</u>	<u>Төслийн байршил:</u>	<u>Салбар чиглэл</u>	<u>Одоогийн байдал:</u>	<u>Төслийн үйл ажиллагаа:</u>	<u>Зураг</u>
100,000,000	Сүхбаатар аймаг Баруун-Урт сум	Тахианы аж ахуй	2023 онд тахианы байр барих зорилгоор 100,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдан 240 мкв тахианы байр нэмж барьсан. Өмнө 2300 тахиатай, өөрийн хөрөнгөөр нэмж 2700 тахиа авсан. Нийт 5000 тахиатай аймгийн төвийн хүнсний 10 дэлгүүрт нийлүүлж байна. Зээл эргэн төлөлт хэвийн.	Зээлийн санхүүжилтээр тахианы аж ахуйн байрыг барьсан. Түмэнцогт сумаас малчин хүмүүс ирж гэр бүлээрээ ажиллаж байна. Төсөл бүрэн хэрэгжсэн.	

АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖСЭН ТӨСЛҮҮДИЙН ТАЛААР

Сүхбаатар аймагт 1.1 тэрбум төгрөгийн үндсэн зээлийн үлдэгдэлтэй 16 **төсөл амжилттай хэрэгжсэн** байна. Үүнээс зарим төслүүдийг онцолбол,

- Эм Ти Си Жи ХХК нь зээлийн санхүүжилтээр ажлын байр барьсан ба 2 малчин иргэн ажлын байраар хангаж, аймгийн хүнсний дэлгүүрт өндөг нийлүүлж, хүн амын өндөгний хэрэгцээг хангаж байна.
- Цэц дөл ХХК зээлийн санхүүжилтээр үхрийн бордооны байр гүний худаг, тугалтай үнээ, бухыг худалдан авсан. Өөрийн хөрөнгө оруулалтаар 220кв тогийг авсан. Мөн Баруун-Урт сумын цэцэрлэг сургуульд үхрийн мах нийлүүлж байна.

• ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ ТӨСЛҮҮДИЙН ТАЛААР

- Төслийн хэрэгжилтийг хянаж үзэхэд **70.0 сая** төгрөгийн үндсэн зээлийн үлдэгдэлтэй **1** төсөл нь үйл ажиллагаа хангалтгүй, зээлийн зарцуулалтаа тайлагнаагүй, үйл ажиллагаа явуулаагүй гэдгээ хүлээн зөвшөөрсөн зэрэг шалтгааныг харгалзан **Төслийн хэрэгжилт хангалтгүй** төлөвт шилжүүлж, албан шаардлага хүргүүлэх, дараагийн дараагийн шатны арга хэмжээ авч ажиллах шаардлагатай гэж үзэв. Тухайлбал,
- 18.Билэгт сувдан нуур ХХК:**


<u>Зээлийн дүн:</u>	<u>Төслийн байршил:</u>	<u>Салбар чиглэл</u>	<u>Одоогийн байдал:</u>	<u>Төслийн үйл ажиллагаа:</u>	<u>Зураг</u>
---------------------	-------------------------	----------------------	-------------------------	-------------------------------	--------------

70,000,000	Сүхбаатар аймаг Баруун-Урт сум	Гутал үйлдвэрлэл	Төслийн хэрэгжилт хангалтгүй. Гэр бүлийн хүн хотод ажиллаж байгаа. Эхнэр Янжинлхам нялх хүүхэдтэй учраас зээлийн зарцуулалтаа тайлагнаагүй, үйл ажиллагаа явуулаагүй гэдгээ хүлээн зөвшөөрсөн.
------------	-----------------------------------	------------------	--

4. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ЧИГЛЭЛЭЭР

2024 оны 10 дугаар сарын 19-20 өдрүүдэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хувьсал”, “Атар – 65 жил”, “Алтан намар 2024” Дархан –Уул аймагт зохион байгуулагдсан арга хэмжээнд оролцсон.

Тус арга хэмжээнд 18 аймгийн агрономич болон газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд хамрагдаж мэдээлэл солилцох, арга хэмжээний нээлтэд оролцож, тоног төхөөрөмж, хүнс, хүнсний ногоо, үр тарианы үзэсгэлэн худалдаатай танилцсан.



ХХААГ-ын даргын баталсан намрын ургац хураалт, үрийн нөөц бүрдүүлэх, цаг үеийн ажлаар зөвлөмж, чиглэл өгөх ажлын удирдамжуудын хүрээнд Газар тариалан эрхлэгч 1 иргэн, 4 аж ахуйн нэгжид Газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг 2024 оны 09 дүгээр сарын 16-ны

өдөр Дорнод монголын хуурай хээрийн төслөөс хөнгөлөлттэй үр авсан иргэн, аж ахуйн нэгжүүдтэй санхүүгийн дэмжлэгийн гэрээ байгуулж ажилласан.



11 сарын 07-ны өдөр УБ хотод Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн төвийн Газар тариалангийн инновац нэвтрүүлэлт хариуцсан мэргэжилтэн С.Нандинцэцэгийн "Хүлэмжийн аж ахуй эрхлэх боломж, эдийн засгийн үр ашгийг тооцох" сэдэвт сургалтанд ХХААГ-ын албадын дарга, мэргэжилтэн 9 сумын Хөдөө аж ахуйн тасгийн нийт 24 мэргэжилтэнүүд хамрагдаж мэдээлэл авсан.



5. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР

Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт:

Нийтээр тэмдэглэх баяр болон цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээний үеэр хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нийт 61 иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналтыг хийж гүйцэтгэсэн байна. Шалгалтаар хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй 13 нэр төрлийн 33 ширхэг 267.7 мянган төгрөгийн хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтын доор устгуулан хэрэглээнээс хасуулах арга хэмжээ авсан. Мөн 40 аж ахуй нэгжийн 12 нэр төрлийн түүхий эд, бүтээгдэхүүнээс 27 дээж авч аймгийн Стандарт хэмжил зүйн болон Мал эмнэлгийн лабораторид шинжилгээнд хамруулахад эерэг сорьц илрээгүй болно. Шалгалтаар 66 зөрчил илрүүлснээс 100 хувийг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авч ажиллалаа. Хүнсний

бүтээгдэхүүний аюулгүй байдал, зохистой хэрэглээ, зөв сонголт, хадгалалт, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 23 аж ахуйн нэгж, 155 иргэнд зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллалаа. Зөрчил дутагдал гаргасан 2 иргэн, аж ахуй нэгжид 1300.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч бүрэн барагдуулсан.

Салбарын хяналтын газрын Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 08-00-5/02 тоот удирдамжийн хүрээнд газар тариалан эрхлэгч нийт 6 иргэн, аж ахуйн нэгж хамрагдлаа. Тус удирдамжийн хүрээнд Хэрлэн-Алтай ХХК-ийн улаан буудайнд ургамлын эрүүл ахуйн үзлэг хийж, зохих журмын дагуу дээж авч Стандарт хэмжил зүйн газрын Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид шинжилгээнд хамрууллаа. 13803 дугаартай сорилтын дүнгээр тус аж ахуйн нэгжийн Алтайская-93 сортын 50 тн тарих үрийн улаан буудай нь шинжлэгдсэн үзүүлэлтийн хүрээнд Үрийн буудай. Сортын болон үрийн чанар. Ерөнхий шаардлага MNS 0246:2010 стандартын 6.1-д заасан тарих үрийн чанарын 3 дугаар ангийн шаардлагыг хангасан тул 08-28-05/449/193 дугаартай улсын байцаагчийн дүгнэлт үйлдэж ажиллалаа.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Боловсрол шинжлэх ухааны яамны салбар хяналтын газруудын улсын ерөнхий байцаагчийн нарын хамтран баталсан 08-00-02/15 дугаартай удирдамжийн дагуу согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлсэн 210 аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж улсын ахлах байцаагчийн 210 дүгнэлт гаргаж ажилласан болно.

Сургалт:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газраас зохион байгуулсан Хүнсний аюулгүй байдал 3 сарын аяны хүрээнд Стандартчилал хэмжилзүйн хэлтэстэй хамтран "Хөдөө аж ахуйн болон эрүүл ахуйн зохистой дадал", "Хүнсний сав баглаа боодлын шошгод тавих шаардлага", "Хуванцар сав түүний төрөл, тэмдэглэгээ" сэдвүүдээр 12 сумын хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 204 иргэн, албан тушаалтан хамруулан сургалт зохион байгуулав.

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АУДИТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН: Ө.ГАНЧИМЭГ